



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/327

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, хамгаалалтын албаны
ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас,
хамгаалах хэрэгслийн эдэлгээний нормыг
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны А/78 дугаар тушаалын 2 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аюулгүй байдал, хамгаалалтын албаны ажилтнуудын ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний нормыг нэгдүгээр хавсралтаар, дүрэмт хувцас олгох албан тушаалын жагсаалт, эдэлгээний нормыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг Аюулгүй байдал, хамгаалалтын алба (М.Гомбожав), хяналт тавьж ажиллахыг Нисэх буудлуудын үйлчилгээний газар (С.Нацагдорж), Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т тус тус даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн
А/327 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Аюулгүй байдал, хамгаалалтын албаны ажилтнуудын ажлын тусгай хувцас,
хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний норм

№	Албан тушаал	Нэр төрөл	Хугацаа
1	2	3	4
1	Албаны дарга, Дэд дарга, Төлөвлөлт, сургалтын хэсгийн дарга, менежер, ахлах мэргэжилтэн, Үзлэг шалгалт, хамгаалалтын хэсгийн дарга, менежер	Ноосон цамц	2 жил
2	Онцгой байдал, зэвсгийн мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн, Бэлтгэл сургууллт, шуурхай ажиллагааны мэргэжилтэн	Өвлийн өмд, куртка	4 жил
		Ноосон цамц	2 жил
		Борооны цув	3 жил
		Гэрэлтдэг хантааз /Онцгой байдал, зэвсгийн мэргэжилтэн/	2 жил
3	Ээлжийн ахлагч, Шуурхай хяналтын ахлагч	Өвлийн өмд, куртка	4 жил
		Өвлийн гутал	4 жил
		Ноосон цамц	2 жил
		Ажлын гутал	2 жил
		Борооны цув	3 жил
4	Зохицуулагч /камерын хяналтын/	Ноосон цамц	2 жил
		Нүдний дусаалга	1 сар
5	Зохицуулагч /талбайн хяналтын/	Өвлийн өмд, куртка	4 жил
		Өвлийн урт түрийтэй үстэй гутал "Унты"	6 жил
		Савхин бээлий	1 жил
		Борооны цув	3 жил
		Усны гутал	3 жил
		Суран бүс, гав, бороохой	4 жил
		Гэрэлтдэг хантааз	2 жил

1	2	3	4
6	Үзлэгийн ахлагч, Аюулгүй байдлын үзлэгийн шалгагч	Өвлийн урт хүрэм	6 жил
		Ноосон цамц	2 жил
		Үзлэгийн цагаан бээлий	1 сар
7	Хамгаалалтын ахлагч, Хамгаалалтын ажилтан	Өвлийн өмд, куртка	4 жил
		Өвлийн гутал	4 жил
		Ноосон цамц	2 жил
		Ажлын гутал	2 жил
		Савхин бээлий	1 жил
		Борооны цув	3 жил
		Усны гутал /хамгаалалтын ажилтан/	3 жил
		Суран бүс, гав, бороохой /хамгаалалтын ажилтан/	4 жил
8	Нохой сургагч мэргэжилтэн, Нохой хөтлөгч шалгагч	Өвлийн өмд, куртка	4 жил
		Ноосон цамц	2 жил
		Брезентэн өмд, цамц /нохой сургагч/	1 жил
		Сургалтын зориулалттай иж бүрэн хувцас /нохой сургагч/	2 жил
		Борооны цув	3 жил
		Усны гутал	3 жил
		Ажлын бээлий	сард 2 хос
		Алчуур	1 сар
		Саван	1 сар
9	Албаны нохой	Сургалтын резин бөмбөг	эдэлгээгээр
		Хушуувч	4 жил
		Хүзүүвч	1 жил
		Урт оосор	1 жил
		Богино оосор	1 жил
		Цээживч	1 жил
		Эргүүлэг түгжээ	1 жил
		Гинж	1 жил
		Нохойн сам	1 жил
		Идүүр	1 жил
		Ариутгал	жилд 2 удаа
		Витамин 200 гр	сард
		Хоол тэжээл 900 гр /1 нохой/	өдөрт